

СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖИД ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурал 2013 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн батлав.

Гадаад улс оронд гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах энэ төрлийн хууль эрх зүйн зохицуулалт байдаг. Тэд стратегийн салбарт зөвшөөрөл авах шаардлагатай хөрөнгө оруулалтын доод хэмжээ, түүнийг шийдвэрлэх байгууллагыг тодорхой заасан нийтлэг зарчимтай аж.

Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль нь анх 2012 онд батлагдсан бөгөөд энэ хууль нь стратегийн ач холбогдол бүхий салбарт хөрөнгө оруулж буй гадаадын хөрөнгө оруулагч этгээдэд зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахаас гадна эдийн засгийн өгөөж, үндэсний үйлдвэрлэл болон бүтээн байгуулалтын бодлого зэргийг Үндэсний аюулгүй байдалтай нийцүүлэн үйлдүүлэн зохицуулахад оршиж байна.

Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой салбарт **“эрдэс баялаг”, “банк, санхүү”, “хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо”**-г оруулан тусгайлан хуульд тусгасан юм.

Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэгт **“4.7.Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн гадаадын хөрөнгө оруулагчийн эзэмших хувь хэмжээ 49 хувиас илүү гарах бөгөөд тухайн үед оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 тэрбум төгрөгнөөс давах тохиолдолд Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ. Бусад тохиолдолд зөвшөөрөл олгох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.”** гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд зарим нэг хүндрэл үүсч байна. Тухайлбал, уул уурхай, банк зэрэг өсч хөгжиж буй салбарт 100 тэрбум төгрөг нь тэр бүр босго болж чадахгүй байна. Мөн жижиг, дунд хэмжээний хөрөнгө оруулалт /уул уурхайн салбарт өрөмдлөг болон тээвэрлэлт хийх зэрэг/ бизнес хэлцэл бүрийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх асуудал үүсээд байсан юм.

Иймд дурдсан хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсгийг **“Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа эрхлэх, эсхүл үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн гадаадын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хөрөнгө оруулагчийн эзэмших хувь хэмжээ 49 хувиас илүү гарах тохиолдолд Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэх бөгөөд бусад тохиолдолд зөвшөөрөл олгох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.”** гэж өөрчлөн найруулснаар 100 тэрбумын босго арилж, зөвхөн төрийн өмчит компанитай холбоотой хэлцлийг Улсын Их Хурал шийдвэрлэж байх, стратегийн ач холбогдол бүхий салбарт гадаадын хөрөнгө оруулалтад тавигдаж буй зөвшөөрөл авах үйл ажиллагаа тодорхой болж, түргэн шуурхай шийдэгдэх боломж бий болно.

Эх сурвалж: <http://www.parliament.mn/news/medeelel/categories/209/pages/6563>